



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 556

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийн
бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 5.3 дугаар зүйлийн 1, 8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.45, 2.48, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12, 63 дугаар зүйлийн 63.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 206 дугаар тогтоолын 1 дэх заалтын “13.8-14.8” гэснийг “14.8-16.0” гэж, “CME term SOFR” гэснийг “Compounded SOFR” гэж тус тус өөрчлөн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар (Б.Дөлгөөн)-т үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан үнэт цаасны танилцуулгад холбогдох өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК (Х.Алтай), “Бидисек ҮЦК” ХК (Б.Лхагвадорж), “ХААН банк” ХК (Р.Мөнхтуяа)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518001385